

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД,
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД,
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙДЫН
ХАМТАРСАН ТУШААЛ

2020 оны ...-р сарын ...

Дугаар

Улаанбаатархот

Журам батлах тухай

Монгол Улсын Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 14.1дахь заалтыг үндэслэн ТУШААХнь:

1. “Хувиргасан амьд организаас гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнд эрсдэлийн үнэлгээ хийх, бүртгэх журам”-ыг баталсугай.

2. “Хувиргасан амьд организаас гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнд эрсдэлийн үнэлгээ хийх, бүртгэх журам”-ыг 2020 оны ... дүгээр сарын 1-нээс эхлэн мөрдсүгэй.

3. Журмын хэрэгжилтийг хангаж ажиллахыг яамдын Төрийн нарийн бичгийн дарга (.....) нарт даалгасугай.

ЭРҮҮЛ МЭНДИЙН
САЙД

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН
САЙД

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН САЙД

ТӨСӨЛ

2019.05.17

**ХУВИРГАСАН АМЬД ОРГАНИЗМААС ГАРАЛТАЙ ХҮНСНИЙ ТҮҮХИЙ ЭД,
БҮТЭЭГДЭХҮҮНД ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ ХИЙХ,
УЛСЫН БҮРТГЭЛД БҮРТГЭХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Монгол улсад хувиргасан амьд организмаас гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг анх удаа импортлох болон дотооддоо хувиргасан амьд организмаас гаралтай түүхий эд ашиглан хүнсний үйлдвэрлэл явуулахаас өмнө эрсдлийн үнэлгээ хийх, тэдгээрийг улсын бүртгэлд бүртгэх харилцааг зохицуулна.

1.2 Анх удаа хувиргасан амьд организмаас гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг импортлох, хувиргасан амьд организмаас гаралтай түүхий эдийг ашиглан дотоодын хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэхээс өмнө эрсдлийн үнэлгээ хийх, тэдгээрийг улсын бүртгэлд бүртгэхэд энэхүү журмыг дагаж мөрдөнө.

1.3 Хувиргасан амьд организм, түүнээс гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнд эрсдлийн үнэлгээ хийх, бүртгэхэд Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай, Хүнсний тухай хууль, Хувиргасан амьд организмын тухай хууль, Биоаюулгүй байдлын тухай Картагены протоколын Хариуцлага ба хохиролгүй болгох тухай Нагоя-Куала Лумпурын нэмэлт протокол болон холбогдох бусад хууль, тогтоомж, гэрээ, хэлэлцээрийг дагаж мөрдөнө.

1.4 Энэхүү журам нь хувиргасан амьд организм, амьтан, бичил биетнийг үржүүлэх, ургамлыг тарималжуулахад хамаарахгүй.

Хоёр. Хувиргасан амьд организмаас гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнд эрсдлийн үнэлгээ хийх

2.1. Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэдэх Биоаюулгүй байдлыг хангах үндэсний хорооны дэргэдэх Шинжээчдийн зөвлөл дараах тохиолдолд эрсдлийн үнэлгээ хийнэ. Үүнд:

- Монгол улсад хувиргасан амьд организмаас гаралтай түүхий эд ашиглан анх удаа хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл явуулахаас өмнө,

- Биоаюулгүйн зуучлагч механизм (Biosafety clearing house)-д бүртгэгдээгүй хувиргасан амьд организмаас гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн импортлох тохиолдолд.

2.2. Биоаюулгүй байдлыг хангах үндэсний хорооны дэргэдэх Шинжээчдийн зөвлөл энэхүү журмын 2-р хавсралтад заасан мэдээллийг үндэслэн 90 хоногт багтаан эрсдлийн үнэлгээг олон улсын батлагдсан арга аргачлалын дагуу хийнэ.

2.3. Биоаюулгүй байдлыг хангах үндэсний хороо нь Шинжээчдийн зөвлөлийн эрсдлийн үнэлгээний тайлан, дүгнэлтийг үндэслэн тухайн хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг импортлох, үйлдвэрлэх эсэх шийдвэрийг Хүнсний болон Хяналтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж, цахимаар олон нийтэд мэдээнэ.

2.4. Хяналтын байгууллагын асуудал хариуцсан улсын байцаагч (экспорт, импортын асуудал хариуцсан) нь хувиргасан амьд организмаас гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний гарал үүсэл баталгаажуулалт, бүрдүүлсэн бичиг баримтад дүн шинжилгээ хийсний үндсэн дээр уг хүнсний түүхий эд нь Биоаюулгүйн зуучлагч механизм (Biosafety clearing house)-д бүртгэгдсэн бол уг хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнд эрсдлийн үнэлгээ хийхгүйгээр улсын бүртгэлд бүртгүүлэх дүгнэлтийг импортлогч, үйлдвэрлэгчдэд хүргүүлнэ.

Гурав. Хувиргасан амьд организмаас гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын бүртгэлд бүртгэх

3.1. Хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь Биоаюулгүй байдлыг хангах үндэсний хорооны шийдвэрийг үндэслэн хувиргасан амьд организмаас гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын бүртгэлд цаасаар болон цахимаар бүртгэх зохион байгуулалтын эрхийг хэрэгжүүлнэ.

3.2. Хувиргасан амьд организмаас гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын бүртгэлд бүртгүүлэхээр хүсэлт гаргагч импортлогч болон дотоодын хүнсний үйлдвэрлэгч нь дараах бичиг баримтыг Хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад цаасаар болон цахимаар ирүүлнэ. Үүнд:

- Албан хүсэлт (Хавсралт 1);
- Хувиргасан амьд организмаас гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний тухай дэлгэрэнгүй танилцуулга
- Үйлдвэрлэгч/ импортлогч аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;
- Хяналтын улсын байцаагчийн дүгнэлт/импортын мэдэгдлийн хуулбар;
- Биоаюулгүй байдлыг хангах үндэсний хорооны шийдвэр /Биоаюулгүйн зуучлагч механизм (Biosafety clearing house)-д бүртгэгдээгүй түүхий эдэд хамаарна/;

3.3. Хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүртгэл хариуцсан мэргэжилтэн хувиргасан амьд организмаас гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг цаасаар болон цахим хэлбэрээр бүртгэж, бүртгэснээ Хүнсний асуудал хариуцсан Засгийн газрын гишүүний тушаалаар баталгаажуулж, ажлын 7 хоногт улсын бүртгэлийн дугаар олгоно.

3.4. Улсын бүртгэлийн дугаар нь 3-5 үсэг 10 тооноос бүрдэнэ. Эхний 3-5 үсэг нь шилжмэл генийн олон улсын код, эхний 3-4 тоо нь олон улсын код, сүүлийн 6 тоо нь бүртгэсэн хугацаа (он, сар)-г илэрхийлнэ.

3.5. Хувиргасан амьд организмаас гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний цахим бүртгэл, мэдээллийн санд тухайн хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнтэй холбоотой дараах мэдээллийг байршуулна.

- Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний нэр (монгол, англи, орос хэл дээр);
- Бүтээгдэхүүн, түүхий эдийн танилцуулга;
- Фото зураг (хайрцаг савтай болон савгүйгээр);
- Шошго;

3.6. Улсын бүртгэлийн дугаартай хувиргасан амьд организмаас гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг нийтийн хэрэгцээнд гарган худалдаалж, үйлдвэрлэлд ашиглана.

3.7. Хэрэглэгч, үйлдвэрлэгч, импортлогч, экспорлогч болон холбогдох мэргэжлийн байгууллага хувиргасан амьд организмаас гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний бүртгэлийн дугаараар мэдээллийн сангаас мэдээлэл авна.

Дөрөв. Бүртгэлийг хүчингүй болгох, мэдээллийн сангаас хасах

4.1. Хувиргасан амьд организмаас гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг дараах тохиолдолд бүртгэлээс хасна.

4.1.1. Хүнсний аюулгүй байдлын олон улсын байгууллагуудын сүлжээгээр хүн амын эрүүл мэндэд аюултай талаарх мэдээлэл ирүүлсэн, олон улсын мэдээллийн жагсаалтаас хасагдсан (INFOSAN, ASEAN, Biosafety clearing house);

4.1.2. Үйлдвэрлэлийн технологи ажиллагаа, жор орц нь өөрчлөгдсөн

4.2. Бүртгэлд өөрчлөлт оруулахад дараах материалыг бүрдүүлнэ.

- Бүртгэлд оруулах тухай хүсэлт;
- Хяналтын байгууллагын асуудал хариуцсан улсын байцаагчийн дүгнэлт
- Бүтээгдэхүүний гарал үүслийн гэрчилгээ;
- Шошго, савлалтын загвар;
- Технологи ажиллагаа, жор орцын мэдээлэл.

4.3. Бүртгэлээс хасагдсан хувиргасан амьд организмаас гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний мэдээллийг ажлын 10 хоногийн дотор мэдээллийн санд өөрчлөлт оруулна.

Эрүүл мэндийн сайд, Хүнс, хөдөө аж ахуй,
хөнгөн үйлдвэрийн сайд, Байгаль орчин,
аялал жуулчлалын сайдын 201...оны ...
дугаар тушаалын 2-р хавсралт

**ХУВИРГАСАН АМЬД ОРГАНИЗМААС ГАРАЛТАЙ ХҮНСНИЙ ТҮҮХИЙ ЭД,
БҮТЭЭГДЭХҮҮНИЙГ УЛСЫН БҮРТГЭЛД БҮРТГҮҮЛЭХ ӨРГӨДӨЛ
/REGISTRATION APPLICATION FORM/**

Холбогдох дөрвөлжинг тэмдэглэх (Type of application (check the box applicabel))

- Шинээр бүртгүүлэх
New registration for a product
- Бүртгэлд өөрчлөлт оруулах
Variation to an existing marketing authorization
- Хугацаа сунгуулах
Renewal of registration

I ХЭСЭГ. PART I ӨРГӨДӨЛ ГАРГАГЧИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ.	
Байгууллагын нэр Name of organization	
Ажлын хаяг Business address	
Шуудангийн хаяг Postal address	
Утасны дугаар Telephone number	
Факсын дугаар Fax number	
Харилцах хүн Contact person	
II ХЭСЭГ. PART II ҮЙЛДВЭРЛЭГЧИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ	
Нэр Name	
Шуудангийн хаяг Postal address	
Утасны дугаар Telephone number	
Факсын дугаар Fax number	
Вэб хаяг Web page	
Харилцах хүн Contact person	
Е-мэйл хаяг E-mail address	
III ХЭСЭГ. PART III БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ	

	Тухайн бүтээгдэхүүний худалдааны нэршил <i>Proprietary name (trade name)</i>	
	Бүтээгдэхүүний зориулалт	
Шилжмэл генийн олон улсын нэр, тодорхойлолт <i>Name and strength of active ingredients</i>		
	Хүчинтэй хугацаа <i>Shelf life</i>	
	Савлалтын хэлбэр	

*Эрүүл мэндийн сайд, Хүнс, хөдөө аж ахуй,
хөнгөн үйлдвэрийн сайд, Байгаль орчин,
аялал жуулчлалын сайдын 2020 оны ...
дугаар тушаалын 3-р хавсралт*

**ХУВИРГАСАН АМЬД ОРГАНИЗМААС ГАРАЛТАЙ ХҮНСНИЙ ТҮҮХИЙ ЭД,
БҮТЭЭГДЭХҮҮНД ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ ХИЙХЭД ШААРДАГДАХ
МЭДЭЭЛЭЛ**

1. Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг үйлдвэрлэхэд ашигласан Рекомбинант-ДНХ бүхий ургамал/амьтан/бичил биетний ерөнхий тодорхойлолт;
2. Эх ургамал/амьтан/бичил биетний тодорхойлолт ба түүний зориулалт; эх ургамал/амьтан/бичил биетний харьцуулсан иж бүрэн бичиглэл;
3. Хүлээн авагч ургамал/амьтан/бичил биетний тодорхойлолт ба түүний зориулалт;
4. Генетикийн өөрчлөлт орсонтой холбогдох молекул-биологи ба биохимийн шинж чанарын талаарх мэдээлэл;
5. Экспресслэгдэж буй нуклейн хүчлийн хоруу чанарын үнэлгээ;
6. Шинээр нийлэгжиж буй уургийн харшил үүсгэх байдалд өгөх үнэлгээ;
7. Гол бүрэлдэхүүн хэсгийн найрлагын шинжилгээ;
8. Хүнсний түүхий эдэд боловсруулалт хийх явцад гарч болзошгүй нөлөөллийн тооцоо;
9. Антибиотикт тэсвэртэй маркер генийн хэрэглээний тооцоо, үнэлгээ;
10. Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг үйлдвэрлэхэд ашигласан хувиргасан амьд организмын хэрэглээний ерөнхий нэр, шинжлэх ухааны нэршил, зүйлийн ангилал зүйн статус;
11. Тухайн хувиргасан амьд организмыг гарган авахад хэрэглэсэн эрлийжжүүлэг ба тариалж/үржүүлж/өсгөвөрлөж ирсэн түүх, ялангуяа хүний эрүүл мэндэд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөний тухай мэдээлэл;
12. Тухайн хувиргасан ургамал/амьтан/бичил биетний генотип, фенотипийн бүрэн мэдээлэл, хоруу чанарын болон харшил үүсгэгч нэгдэл /бодис/-ийн талаарх мэдээлэл;
13. Хүнс эсхүл хүнсний үйлдвэрлэлд аюулгүй хэрэглэх тухай заавар, зөвлөмж;
14. Тухайн хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнд дулааны боловсруулалт хийгдээгүй тохиолдолд Рекомбинант-ДНХ бүхий ургамал/амьтан/бичил биетнээс хүний биеийн хоол боловсруулах эрхтэн тогтолцоонд үзүүлэх нөлөөллийн талаарх мэдээлэл;
15. Тухайн хувиргасан ургамал/амьтан/бичил биетний хүний биед харшил үүсгэх уураг, амин хүчлийн гомолог дараалал, пепсинд тэсвэртэй чанар, өвөрмөц ийлдсийн хэмжээ;
16. Тухайн бүтээгдэхүүний савлалт, баглаа боодлын үзүүлэлтүүд;

Хууль зүйн сайдын 2019 оны дугаар сарын.....-ний өдрийндугаар тушаалын хавсралт “Захиргааны хэм хэмжээний актын төсөл бэлтгэх явцад нөлөөллийн шинжилгээ хийх аргачлал”-ын дагуу боловсруулав.

“ХУВИРГАСАН АМЬД ОРГАНИЗМААС ГАРАЛТАЙ ХҮНСНИЙ ТҮҮХИЙ ЭД, БҮТЭЭГДЭХҮҮНД ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ ХИЙХ, БҮРТГЭХ ЖУРАМ”-ЫН ТӨСӨЛД ХИЙСЭН НӨЛӨӨЛЛИЙН ШИНЖИЛГЭЭ

1. Журам гаргах үндэслэл, шаардлага, зорилт

Үндэслэл:

Хүнсний тухай хуулийн 7 дугаар зүйл. “Хувиргасан амьд организмаас гаралтай хүнс”-ийн

“7.1.Удамшлын мэдээллийн шинэ хослол бүхий аливаа амьд организмаас гарган авсан хүнсийг хувиргасан амьд организмаас гаралтай хүнс гэнэ.

7.2.Хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 14.1-д заасан журмын дагуу хувиргасан амьд организмаас гаралтай хүнсийг бүртгэнэ.

7.3.Хувиргасан амьд организмаас гаралтай импортын хүнсний талаар хүнсний хяналтыг хэрэгжүүлэх төрийн захиргааны байгууллага /цаашид “хяналтын байгууллага” гэх/ болон биоаюулгүй байдлын асуудал эрхэлсэн байгууллага цахим хэлбэрээр нийтэд мэдээнэ.

7.4.Гадаадын зээл, тусламжаар хувиргасан амьд организмаас гаралтай хүнс авахыг хориглоно” заалтууд

Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 14 дүгээр зүйл. “Хувиргасан амьд организмаас гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн”-ийн

“14.1.Хувиргасан амьд организмаас гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнд эрсдэлийн үнэлгээ хийх, тэдгээрийг бүртгэх журмыг эрүүл мэнд, хүнсний болон байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран батална.

14.2.Эхний удаа импортолсон болон дотооддоо үйлдвэрлэсэн хувиргасан амьд организмаас гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнд хяналтын байгууллага хяналт шалгалт хийнэ.

14.3.Энэ хуулийн 14.1-д заасан журмын дагуу эрсдэлийн үнэлгээ хийлгээгүй, бүртгүүлээгүй хувиргасан амьд организмаас гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэхийг хориглоно” гэсэн заалтууд энэхүү журмын төслийг боловсруулах эрх зүйн үндэслэл болсон.

Шаардлага:

Дэлхийн улс орнууд 1970-аад оноос генийн инженерчлэл буюу ДНХ-рекомбинант технологийг туршин шинэ төрлийн бичил биетэн, ургамал, амьтдыг гарган авсан. Өөөрөр

хэлбэл нэг амьд бодгальд буй онцлог давуу шинж чанартай генийг нөгөө амьд бодгальд суулган шинэ төрөл, зүйлийг гарган авах технологи юм. Дэлхий дээр генийн өөрчлөлтэй хамгийн түгээмэл ургамал бол эрдэнэ шиш, шар буурцаг, рапс, хөвөнгийн сорт зэрэг генийн өөрчлөлттэй таримал ургамлууд. Ийм сортууд нь ургамлын хортон шавьж, хог ургамалд тэсвэртэй байдлыг хангах үүднээс генетикийн хувьд өөрчлөгдсөн байдаг.

Нөгөө талаар хүн амын өсөн нэмэгдэж буй хүнсний хангамж, шим тэжээлийн болон эрүүл мэндийн асуудлыг шийдвэрлэхэд ашиглаж байна. Тухайлбал: Азийн зарим орнуудад А аминдэмийн дуталтай хүн амын эзлэх хувь өндөр байдаг. Иймд уг орнууд лууванд байдаг А аминдэм нийлэгжүүлдэг ашигтай генийг ялган авч цагаан будааны генийн гинжин хэлхээнд суулган А аминдэм өндөртэй шаргал өнгөтэй цагаан будааг гарган авч хүн амын дунд түгээмэл тохиолдож буй А аминдэмийн дутлаас сэргийлж байна.

Биотехнологи, генийн инженерчлэлийн шинжлэх ухааны ололт нь дэлхийн хүн амын хүнсний хангамж, шим тэжээлийг дутлаас сэргийлэх асуудлыг шийдвэрлэхэд чухал үүрэг гүйцэтгэж байгаа хэдий ч дэлхийн улс орнууд хувиргасан амьд организм, тэдгээрээс гаралтай хүнсний түүхий эд бүтээгдэхүүнээс үүсч болзошгүй эрсдлийг тооцох, түүнд тавих хяналтыг чангатгах, хүрээлэн буй орчин, хүний эрүүл мэндэд үзүүлж болзошгүй хор аюулаас урьдчилан сэргийлэх тогтолцоог буй болгох шаардлага гарсан.

Европын холбоо хүний эрүүл мэнд, байгаль орчныг хамгаалах зорилгоор генийн инженерчлэлтэй холбоотой хууль тогтоомжийг 1990-ээд оны эхэн үеэс батлан хэрэгжүүлж ирсэн. Өөрөөр хэлбэл Европын Холбооны улс орнууд генийн өөрчлөлттэй таримал ургамал, амьтдын аюулгүй хөдөлгөөнийг хангах, хил дамнасан хөдөлгөөнийг зохицуулах (ЕС) 1946/2003-р журам; GMO агуулсан хүнс, тэжээл, тэдгээрийн бүтээгдэхүүнийг зах зээл дээр гаргах тухай 1829/2003 дүрмийг батлан холбооны улс орнууд хатуу мөрдөн ажилладаг.

Монгол Улсын Хувиргасан амьд организмын тухай хуульд “Хувиргасан амьд организм гэдэг нь орчин үеийн биотехнологийн аргаар гарган авсан удамшлын мэдээллийн шинэ хослол бүхий аливаа амьд организм”-ыг хэлнэ гэж заасан ба биологийн олон янз байдлыг хамгаалах, зохистой ашиглах, генетик нөөцийг ашигласнаар гарах үр ашгийг шударга, тэгш хуваарилах үндсэн зорилгын хүрээнд ажилладаг Биологийн олон янз байдлын конвенцид нэгдэн Монгол Улс 1992 онд гарын үсэг зурж, Улсын Их Хурал 1993 онд соёрхон баталжээ.

Мөн хувиргасан амьд организмтай холбоотой харилцааг зохицуулах, үүсч болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх зорилгоор 2000 онд батлагдсан Монреалийн Биоаюулгүй байдлын Картагены протоколыг Монгол Улс 2002 онд соёрхон баталж, 2003 оноос мөрдөж эхэлсэн. Өнөөдрийн байдлаар протоколд дэлхийн 188 орон нэгдэн орсон байна. Уг протоколд нэгдэн орсноор манай улс хувиргасан амьд организмтой холбоотой харилцааг зохицуулах үүргийг олон улсын өмнө хүлээх болжээ. Картагены протоколын үндэсний хэрэгжүүлэгч байгууллага нь БОАЖЯ-ны дэргэд 2008 онд байгуулагдсан Биоаюулгүй байдлыг хангах үндэсний хороо юм. Уг үндэсний хороо нь хувиргасан амьд организмтай холбоотой харилцааг зохицуулдаг бөгөөд протоколыг хэрэгжүүлэх хууль, тогтоол, журам, зөвлөмжийг боловсруулж, батлуулж, хэрэгжүүлэх үүрэгтэй ажилладаг.

Улс орон бүр хувиргасан амьд организм, тэдгээрээс гаралтай хүнсний түүхий эд бүтээгдэхүүний тариалалт, үйлдвэрлэл, импорт, худалдаанд онцгой анхаарлаа хандуулж,

лого, тэмдэглэгээтэй худалдаалах, шошгонд заавал мэдээлэх, тэдгээрийг улсын бүртгэл бүртгэж, үйлдвэрлэл, худалдаа, импортод хяналт тавьдаг байна. Тухайлбал:

- ОХУ-ын Засгийн газар “Генийн өөрчлөлттэй организмыг байгаль орчинд гаргах, эдгээрээс гаралтай бүтээгдэхүүнийг улсын бүртгэлд бүртгэх тухай” (“О государственной регистрации генно-инженерно-модифицированных организмов, предназначенных для выпуска в окружающую среду, а также продукции, полученной с применением таких организмов или содержащей такие организмы”) ОХУ-ын ЗГ-ын 2013 оны 839 дугаар тогтоолын хүрээнд “Байгаль орчинд гаргахаар зорьж буй генийн өөрчлөлттэй организм, ийм төрлийн организм ашиглан үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг улсын бүртгэлд бүртгэх журам”-ыг баталсан. Энэхүү журмаар мэргэжлийн хяналтын улсын байгууллага нь хүнсний үйлдвэрлэлд ашиглагдах хувиргасан амьд организмаас гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг; Мал эмнэлэг, хорио цээрийн хяналтын улсын алба нь ОХУ-ын нутаг дэвсгэр дээр үржүүлэх, тариалах, эмийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, мал эмнэлгийн зориулалтаар ашиглах эм, малын тэжээлд ашигладаг хувиргасан амьд организм буюу ургамал, амьтан, бичил биетнийг улсын бүртгэлд бүртгэх асуудлыг хариуцдаг байна.
- ЕХ-ны улс орнууд ГӨ-тэй хүнс, тэжээлийг шошголох, ул мөрийг мөрдөн мөшгих, хянах, хадгалах журмын тухай 1829/2003, 1830/2003 дугаартай дүрмийг баталсны дараа уг дүрмийг мөрдөж ажиллах эрсдлийн үнэлгээ, хяналт тандалт хийх, мэдэгдэл илгээх, дээж авах, илрүүлэх зэрэг удирдамжуудыг батлан, хатуу чанд мөрдөж ажилладаг.

Иймд эхний удаа Монгол улсад хувиргасан амьд организмаас гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг импортлох, хувиргасан амьд организмаас гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн ашиглан дотооддоо үйлдвэрлэхээс өмнө эрсдлийн үнэлгээ хийх, тэдгээрийн үйлдвэрлэл, импорт, худалдаалтад хяналт тавих, хүн амын эрүүл мэндийг эрсдлээс урьдчилан сэргийлэх зорилгоор “Хувиргасан амьд организмаас гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнд эрсдэлийн үнэлгээ хийх, тэдгээрийг бүртгэх журам”-ыг батлах зайлшгүй шаардлагатай юм.

Зорилт:

1. [Аж ахуйн нэгж, байгууллагын](#) эхний удаа импортлох хувиргасан амьд организмаас гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн болон хувиргасан амьд организмаас гаралтай дотоодын үйлдвэрийн хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын бүртгэлд бүртгэх,
2. Хувиргасан амьд организмаас гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн импортлогч, хувиргасан амьд организмаас гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн ашиглан дотоодын үйлдвэрлэл явуулж буй хуулийн этгээд дагаж мөрдөх,
3. Хэрэглэгч, үйлдвэрлэгч энэхүү мэдээлэлтэй танилцах,
4. Төрийн байгууллагууд мэргэжлийн түвшинд хувиргасан амьд организмаас гаралтай импортын хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн болон хувиргасан амьд организмаас гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн ашиглан дотоодын үйлдвэрлэлийн талаар харилцан мэдээлэл солилцох, ашиглах.

3. Журмын ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хүнсний тухай хууль, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн хүрээнд нийтийн ашиг сонирхол, хүний эрүүл мэнд хүрээлэн буй орчин, улс орны аюулгүй байдалд эрсдэл учруулахгүй байх зорилгоор Монгол Улсад бүртгэлтэй импортын хувиргасан амьд организмаас гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн, хувиргасан амьд организмаас гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн ашиглан дотоодын үйлдвэрийн хүнсийг үйлдвэрлэх, худалдах, төрийн байгууллагууд албан хэрэгцээнд мэдээлэл солилцох, түүнчлэн хэрэглэгчдэд мэдээлэл өгөх үүрэгтэй.

“Хувиргасан амьд организмаас гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнд эрсдэлийн үнэлгээ хийх, бүртгэх журам” нь 4 бүлэгтэй: Үүнд:

- Нийтлэг үндэслэл
- Хувиргасан амьд организмаас гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнд эрсдэлийн үнэлгээ хийх
- Хувиргасан амьд организмаас гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын бүртгэлд бүртгэх
- Бүртгэлийг хүчингүй болгох, мэдээллийн сангаас хасах

4. Журам батлагдсаны дараа эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх бүлгийг тодорхойлох

Журмын хэрэгжилтэд төрийн байгууллагууд, хүнс үйлдвэрлэгч болон импортлогч аж ахуйн нэгж, иргэд оролцоно.

Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх бүлэг нь хүнс үйлдвэрлэгч болон импортлогч аж ахуйн нэгж.

5. Хүний эрх, эрх чөлөө, өрсөлдөөнийг хязгаарласан, эдийн засаг, нийгмийн болон бусад үйл ажиллагаанд саад хориг учруулсан, аливаа хүнд суртал, авлига гарах нөхцөл боломж бүрдүүлсэн байж болзошгүй зохицуулалт агуулж байгаа эсэх

Журам батлагдснаар хүний эрх, эрх чөлөө, жендерийн эрх тэгш байдлыг хязгаарлах, дотоодын болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн хооронд ямар нэгэн өрсөлдөөн бий болгох, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг зогсооход хүргэх, эдийн засаг, нийгмийн болон бусад үйл ажиллагаанд саад хориг учруулсан, аливаа хүнд суртал, авилга үүсэх зохицуулалт агуулаагүй болно.

Мөн хязгаарлагдмал өрсөлдөөний улмаас үнийн хөөрөгдлийг бий болохгүй, төрийн байгууллага болон аж ахуйн нэгж байгууллагад захиргааны шинж чанартай нэмэлт ачаалал үүсэхгүй, одоо байгаа төрийн байгууллагын бүтэц, үйл ажиллагаан дээр тулгуурлан улсын бүртгэл явагдана.

6. Журмыг хэрэгжүүлснээр эдийн засагт үзүүлэх үр нөлөө, үр дагаврыг үзүүлэх нөлөөлөл

1.Журмыг Монгол Улсын Засгийн газар, төрийн байгууллагууд, хүнс үйлдвэрлэгч, хэрэгжүүлснээр импортлогч аж ахуйн нэгж, хэрэглэгч. нөлөө үзүүлэх зорилтот бүлэг болон бусад бүлэг

2. Эдийн засагт Монгол Улсын Үндсэн хууль, Үндэсний аюулгүй байдлын тухай хууль, үзүүлэх үр нөлөө, Хүнсний тухай хууль, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах үр дагаврыг бусад актыг хүрээнд нийтийн ашиг сонирхол, хүний эрүүл мэнд, үзүүлэх нөлөөлөл хүрээлэн буй орчин, улс орны аюулгүй байдалд хохирол учруулахгүй байх зорилгоор улсын бүртгэлд бүртгэлтэй хувиргасан амьд организаас гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэх, үйлдвэрлэх, импортлоход энэхүү журмыг мөрдөнө.

Хууль бус хүнсний түүхий эдийн импорт, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөтэйг нь олон улсад зарласан хувиргасан амьд организаас гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг ашиглан үйлдвэрлэл явуулах үйл ажиллагааг таслан зогсоох, улмаар улсын бүртгэлтэй хүнс үйлдвэрлэгч, импортлогч аж ахуйн нэгжийн хоорондын импорт, худалдааг зохицуулах ач хобогдолтой.

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлыг хангах, хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчныг аливаа эрсдлээс хамгаалах, урьдчилан сэргийлэх ач холбогдолтой.

7. Журмыг хэрэгжүүлснээр нийгмийн хөгжилд үзүүлэх нөлөөлөл

Журмыг хэрэгжүүлснээр дэлхийн улс орнуудын баримталж буй туршлагаар эрсдэлийн үнэлгээ хийж, улсын бүртгэлд бүртгэгдсэн хувиргасан амьд организаас гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг импортлох, үйлдвэрлэх, зах зээл дээр худалдан борлуулах, хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах, хэрэглэгчийн эрх, ашгийг хамгаалах, бүтээгдэхүүнд хэрэглэгчийн итгэх итгэл нэмэгдэх, хүн амын дундах хүнснээс шалтгаалсан халдварын бус өвчлөл буурах эерэг нөлөө үзүүлнэ.

8. Журмыг хэрэгжүүлснээр дагаж мөрдөж байгаа хууль тогтоомж болон эрх зүйн тогтолцоонд үзүүлэх нөлөө

Журмыг хэрэгжүүлэхэд шаардлагатай хууль, эрх зүйн акт - Зөрчлийн тухай хууль

Хариуцах байгууллагууд - Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
- Эрүүл мэндийн яам
- Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
- Гаалийн ерөнхий газар

9. Журмыг хэрэгжүүлснээр одоогийн байдлаар үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагын (институцийн) тогтолцоонд үзүүлэх нөлөө

Төрийн удирдлагын үйл ажиллагаа, бүтцэд үзүүлэх нөлөө

(шинээр бүтэц бий болох, өнөөгийн институцийг татан буулгах, эсхүл бүтцийг өөрчлөн байгуулах)

Хүний нөөцөд үзүүлэх нөлөө

Холбогдох хариуцах байгууллагын бүтцэд өөрчлөлт орохгүй.

ХХААХҮЯ-ны Хүнсний үйлдвэрийн хөгжлийн бодлого, зохицуулалтын газар хариуцна.

Байгууллагын орон тоонд өөрчлөлт орохгүй болно.